



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/242

Увснбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 303 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 71 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Удирдлагын академитай хамтарсан багийн Засаг дарга нарыг чадавхжуулах сургалтыг хөтөлбөрийн дагуу чанартай зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Я.Жаргалцэцэг)-т даалгасугай.
- Сургалтын үйл ажиллагаанд шаардагдах 15.158.000 (Арван таван сая нэг зуун тавин найман мянга) төгрөгийг баталсан зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.
- Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

